



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/215

Булган

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Хялганат тосгоны сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрын өргөтгөлийн ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу "Агуут ажнай" ХХК-ийг сонгож 46 501 166 /Дөчин зургаан сая таван зуун нэг мянга нэг зуун жаран зургаа/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай


2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээг байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Агуут ажнай" ХХК /Ш.Мягмардаш/-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журам гэрээний дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190225

Аймгийн Засаг даргын 2019 оны ..... сарын .....  
өдрийн ..... дүгээр захирамжийн 1-р хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн /хувь/	Хариуцах албан тушаалтан
1	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	395,086	Ү.Бямбасүрэн
2	Магадлашгүй ажил	790,173	Ү.Бямбасүрэн
3	Захиалагчийн албаны зардал	790,173	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	995,112	Ү.Бямбасүрэн
5	Орон нутгаас авах ажиллах хүчний тоо	5 хүн	Н.Батжаргал
6	Алданги	Хоногт гэрээний үнийн дүнгийн 0.1 хувь	Д.Батцогт
7	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 25 хоног	Ү.Бямбасүрэн